

# ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүмбэр сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГСА-2026/001/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Говьсүмбэр  
аймаг

2026 он

Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын  
дарга, Тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа Утас:  
70543179, Цахим хаяг: [sarantuyab@audit.gov.mn](mailto:sarantuyab@audit.gov.mn)

Аудитын менежер: Г.Наранбаяр

Цахим хаяг: [naranbayarg@audit.gov.mn](mailto:naranbayarg@audit.gov.mn)

Аудитор: С.Батцэцэг

Цахим хаяг: [battsetsegsa@audit.gov.mn](mailto:battsetsegsa@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу..

## Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



### ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг

Утас/Факс: 976-7054 3179

И-мэйл: govissumber@audit.gov.mn

᠒᠐᠒᠖.᠐3.᠒᠘ № 58

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

#### **Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-т заасны дагуу Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### **Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хамрагдсан байгууллагуудад дараах материаллаг хэмжээний зөрчлүүд илэрсэн байна. Тухайлбал:

1. Санхүүгийн тайлангийн аудитаар ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийгдээгүй тайланг нэгтгэж өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, өмнөх онд "Энхтусдэм" өрхийн эрүүл мэндийн төвд илүү олгосон санхүүжилтийн авлагыг барагдуулаагүй он дамжсан, авлагыг барагдуулах талаар үр дүнтэй арга хэмжээ авч ажиллаагүй, татварын орлогын төлөвлөгөөг бүрэн биелүүлээгүй зэрэг нийт 1,461.3 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давж, дангаар буюу нийт дүнгээрээ материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлагналын нийцсэн ба зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй.

4226050261

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 " үнэн зөв байх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Гол үндэслэл нь MNS 6817-1:2020 "Төрийн аудит. Тулгуур зарчим":6 төрийн аудитын зарчим, 6.4.3.1.3 Санал дүгнэлт, 6.4.3.1.3.1 Хязгаарлалттай - Аудитор шалгах зүйлд багтсан материаллаг боловч өргөн тархаагүй тодорхой зүйлийн талаар хангалттай ба зохистой нотлох зүйл олж авах боломжгүй эсвэл зөвшөөрөхгүй байгаа нөхцөлтэй санал нийлэхгүй үед, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2022 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн А/66 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан АДБОУС 200 "Санхүүгийн аудитын зарчим" стандартын 64-т Аудитор нь дараах гурван төрлийн өөрчлөлттэй санал дүгнэлтийг гаргаж болно: хязгаарлалттай санал дүгнэлт - аудитор буруу илэрхийлэл дангаараа эсхүл нийлээд материаллаг боловч өргөн тархаагүй, эсхүл байж болзошгүй буруу илэрхийллийн талаар хангалттай, зохистой аудитын нотолгоо олж авах боломжгүй гэж дүгнэсэн үед, 78-т Санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийж буй аудитор нь санхүүгийн нэгтгэсэн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалд нийцүүлж бэлтгэсэн эсэхэд санал дүгнэлт өгөхийн тулд түүний бүрэлдэхүүн тайлангуудын санхүүгийн мэдээлэл, нэгтгэлийн үйл явцын найдвартай байдлын талаар хангалттай, зохистой аудитын нотолгоог бүрдүүлэх шаардлагатай гэж заасан.

#### **Асуудлыг онцолсон хэсэг**

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тус байгууллага нь бүх үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

#### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

#### **Бусад асуудлын хэсэг**

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

#### **Санхүүгийн нэгтгэсэн тайланд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.


Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.САРАНТУЯА



**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ****2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан**

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>		5,235,236.1	3,814,963.7
31	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	3а, 3б	3,099,807.5	1,905,711.7
33	<b>АВЛАГА</b>	5а, 5б, 6а, 6б	670,094.5	473,659.5
34	<b>УРЬДЧИЛГАА</b>	7а, 7б	322.2	335.7
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	8а, 8б, 8в	1,448,821.9	370,905.5
36	<b>НӨӨЦИЙН БАРАА</b>	9а	16,190.0	1,064,351.4
360	<b>БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ</b>	10	0.0	0.0
2	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>		1,716,272.5	1,870,187.1
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	12а, 12б, 12в	1,716,272.5	1,870,187.1
39200	Биет хөрөнгө		1,561,769.8	1,716,483.1
39300	Биет бус хөрөнгө	13	154,502.8	153,704.0
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>		<b>6,951,508.6</b>	<b>5,685,150.8</b>
4	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>		214,848.5	166,869.3
41	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	15а, 15б	214,848.5	166,869.3
41300	Өглөг	17а, 17б	214,848.5	166,869.3
41400	Урьдчилж орсон орлого	18а, 18б	0.0	0.0
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>		6,736,660.2	5,518,281.5
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>		6,736,660.2	5,518,281.5
51100	Засгийн газрын оруулсан капитал		1,038,822.5	1,038,822.5
51200	Хуримтлагдсан үр дүн		5,540,794.1	4,324,155.4
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		157,043.6	155,303.6
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>		<b>6,951,508.6</b>	<b>5,685,150.8</b>

**2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан**

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>		<b>14,252,614.0</b>	<b>14,948,839.3</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>		<b>9,860,128.2</b>	<b>11,166,760.4</b>
110	Орлогын албан татвар		8,728,477.9	9,889,765.6
1100	Хувь хүний орлогын албан татвар		9,049,920.8	9,889,765.6
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		-321,442.8	-
113	Хөрөнгийн албан татвар		484,750.1	548,813.6
118	Бусад татвар, төлбөр, хураамж		646,900.2	728,181.2
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1а, 1б</b>	<b>1,088,764.6</b>	<b>3,782,078.9</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>		<b>1,088,764.6</b>	<b>358,039.7</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>		<b>3,303,721.3</b>	<b>902,881.8</b>
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2а, 2б</b>	<b>13,911,538.6</b>	<b>16,143,503.22</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>13,911,538.6</b>	<b>16,143,503.22</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		<b>8,259,529.9</b>	<b>7,344,840.69</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		2,134,389.4	2,275,220.93
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		250,990.7	255,764.34
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		1,437,567.7	1,606,185.12
2104	Хангамж, бараа материалын зардал		2,730,297.9	2,373,561.4
2105	Нормативт зардал		170,338.2	127,004.07
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		116,078.9	97,793.7
2107	Томилолт, зочны зардал		37,236.4	23,630.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		866,643.6	128,241.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		515,987.0	457,439.9
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>		<b>5,652,008.7</b>	<b>8,798,662.5</b>

III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		341,075.4	-1,194,663.94
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		62,547.6	-18,531.6
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		278,527.8	-1,213,195.5

### 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)		13,326,895.2	14,681,401.9
2	ТАТВАРЫН ОРЛОГО		9,860,128.2	11,166,760.4
3	Орлогын албан татвар		8,728,477.9	9,889,765.6
4	Хувь хүний орлогын албан татвар		9,049,920.8	9,889,765.6
5	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		-321,442.8	-
6	Хөрөнгийн албан татвар		484,750.1	548,813.6
7	Бусад татвар, төлбөр, хураамж		646,900.2	728,181.2
8	Бусад нийтлэг төлбөр, хураамж		293,374.5	289,639.5
9	Газрын төлбөр		242,457.3	376,108.4
10	Байгалийн нөөц ашигласны төлбөр		111,068.4	62,433.2
11	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		163,744.1	3,514,641.6
12	Нийтлэг татварын бус орлого		163,744.1	241,975.1
13	Тусламжийн орлого		-	931,416.6
14	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг		-	2,341,250.
15	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		3,303,022.9	-
16	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		11,093,217.8	13,746,802.7
17	УРСГАЛ ЗАРДАЛ		11,093,217.8	13,746,802.7
18	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		5,431,450.2	6,320,164.0
19	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		2,143,615.2	2,281,399.8
20	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		254,947.0	260,510.3

21	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		1,441,460.7	1,603,398.4
22	Хангамж, бараа материалын зардал		98,359.6	54,663.9
23	Нормативт зардал		70,984.5	72,101.2
24	Эд хогшил, урсгал засварын зардал		141,215.5	105,496.5
25	Томилолт, зочны зардал		37,236.4	23,630.0
26	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		889,557.7	1,543,576.1
27	Бараа үйлчилгээний бусад зардал		354,073.5	375,387.9
28	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		5,661,767.6	7,426,638.6
29	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)		2,233,677.4	934,599.2
30	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)		2,349,240.2	2,127,405.0
31	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		2,349,240.2	2,127,405.0
32	Дотоод эх үүсвэрээр		2,349,240.2	2,127,405.0
33	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)		-2,349,240.2	-2,127,405.0
34	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН		-1,130.0	-1,290.0
35	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ		1,130.0	1,290.0
36	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)		-116,692.8	-1,194,095.81
37	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		3,216,500.3	3,099,807.48
38	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		3,099,807.5	1,905,711.68

#### **2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

**/мянган төгрөгөөр/**

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,385,372.1	0.0	6,385,372.1

2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	46,443.8	0.0	46,443.8
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,431,815.9	0.0	6,431,815.9
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-45,777.6	0.0	-45,777.6
9	Тайлант үеийн үр дүн	72,094.0	0.0	72,094.0
<b>10</b>	<b>2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	278,527.8	0.0	278,527.8
<b>11</b>	<b>2025 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл</b>	6,736,660.2	0.0	6,736,660.2
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-3,443.15	0.0	-3,443.15
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,733,217.0	0.0	6,733,217.0
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-1,740.0	0.0	-1,740.0
19	Тайлант үеийн үр дүн	-1,213,195.51	0.0	-1,213,195.51
<b>20</b>	<b>2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл</b>	5,518,281.49	0.0	5,518,281.49

**2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан****/мянган төгрөгөөр/**

<b>№</b>	<b>Дансны нэр, төрөл</b>	<b>2024 оны 12-р сарын 31</b>	<b>2025 оны 12-р сарын 31</b>
1	3.1.01.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	14,126,325.7	13,710,065.33
2	3.1.01.1.1 Татварын орлого	11,560,193.7	11,166,760.35
3	3.1.01.1.1.1 Орлогын албан татвар	10,495,250	9,889,765.58
4	3.1.01.1.1.1.1 Хувь хүний орлогын албан татвар	10,495,250	9,889,765.58
5	3.1.01.1.1.1.1.01 Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	9,294,000	8,723,370.78
6	3.1.01.1.1.1.1.02 Үйл ажиллагааны орлого	87,250	136,126.75
7	3.1.01.1.1.1.1.03 Хөрөнгийн орлого	503,500	360,203.61
8	3.1.01.1.1.1.1.04 Хөрөнгө борлуулсны орлого	264,000	203,669.52
9	3.1.01.1.1.1.1.07 Шууд бус орлого	346,500	466,394.92
10	3.1.01.1.1.3 Хөрөнгийн албан татвар	431,810	548,813.61
11	3.1.01.1.1.3.1 Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	428,000	476,609.41
12	3.1.01.1.1.3.2 Бууны албан татвар	3,810	5,107.5
13	3.1.01.1.1.3.4 Малд ногдуулах албан татвар	0	67,096.7
14	3.1.01.1.1.8 Бусад татвар, төлбөр, хураамж	633,133.7	728,181.17
15	3.1.01.1.1.8.1 Бусад нийтлэг төлбөр, хураамж	243,060	289,639.53
16	3.1.01.1.1.8.1.01 Улсын тэмдэгтийн хураамж	8,000	28,255.61
17	3.1.01.1.1.8.1.06 Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	22,000	16,780.85
18	3.1.01.1.1.8.1.08 Хог хаягдлын үйлчилгээний хураамж	213,060	244,603.07
19	3.1.01.1.1.8.2 Газрын төлбөр	336,000	376,108.43
20	3.1.01.1.1.8.2.01 Газрын төлбөр	336,000	376,108.43
21	3.1.01.1.1.8.3 Байгалийн нөөц ашигласны төлбөр	54,073.7	62,433.21
22	3.1.01.1.1.8.3.02 Ан амьтны нөөц ашигласны төлбөр	54,073.7	62,433.21
23	3.1.01.1.2 Татварын бус орлого	2,566,132	2,543,304.98
24	3.1.01.1.2.1 Нийтлэг татварын бус орлого	184,882	202,054.98
25	3.1.01.1.2.1.3 Торгуулийн орлого	0	11,880.4

26	3.1.01.1.2.1.4 Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	171,623	169,154.78
27	3.1.01.1.2.1.5 Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	13,259	9,322.61
28	3.1.01.1.2.1.6 Түрээсийн орлого	0	10,682.19
29	3.1.01.1.2.1.9 Бусад орлого	0	1,015
30	3.1.01.1.2.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	2,381,250	2,341,250
31	3.1.01.1.2.4.2 Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	2,381,250	2,341,250
32	3.1.01.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	16,977,788.56	14,849,329.6
33	3.1.01.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ	13,667,272.76	12,712,748.41
34	3.1.01.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,601,082.5	5,291,279.77
35	3.1.01.2.1.1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,675,647.3	1,622,207.72
36	3.1.01.2.1.1.1.01 Үндсэн цалин	677,424.2	657,419.07
37	3.1.01.2.1.1.1.02 Нэмэгдэл	797,226.5	747,713.41
38	3.1.01.2.1.1.1.03 Унаа хоолны хөнгөлөлт	91,240	117,990.39
39	3.1.01.2.1.1.1.04 Урамшуулал	109,756.6	99,084.85
40	3.1.01.2.1.1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	210,156.2	179,743.5
41	3.1.01.2.1.1.2.01 Тэтгэврийн даатгал	140,602.2	127,058.13
42	3.1.01.2.1.1.2.02 Тэтгэмжийн даатгал	17,388.4	14,859.59
43	3.1.01.2.1.1.2.03 ҮОМШӨ-ний даатгал	8,694.2	7,884.09
44	3.1.01.2.1.1.2.04 Ажилгүйдлийн даатгал	8,694.2	6,005.36
45	3.1.01.2.1.1.2.05 Эрүүл мэндийн даатгал	34,777.2	23,936.33
46	3.1.01.2.1.1.3 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,714,438	1,583,522.4
47	3.1.01.2.1.1.3.01 Гэрэл, цахилгаан	147,160	133,417.88
48	3.1.01.2.1.1.3.02 Түлш, халаалт	1,361,120	1,270,952.76
49	3.1.01.2.1.1.3.03 Цэвэр, бохир ус	206,158	179,151.77
50	3.1.01.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал	40,600	32,149.59
51	3.1.01.2.1.1.4.01 Бичиг хэрэг	8,500	8,038.5
52	3.1.01.2.1.1.4.02 Тээвэр, шатахуун	22,000	16,150
53	3.1.01.2.1.1.4.03 Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,750	3,642.09

54	3.1.01.2.1.1.4.05 Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	850	630
55	3.1.01.2.1.1.4.06 Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,500	3,689
56	3.1.01.2.1.1.6 Эд хогшил, урсгал засварын зардал	130,000	117,593.11
57	3.1.01.2.1.1.6.01 Багаж, техник, хэрэгсэл	18,500	15,738.3
58	3.1.01.2.1.1.6.03 Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,000	0
59	3.1.01.2.1.1.6.04 Урсгал засвар	110,500	101,854.81
60	3.1.01.2.1.1.7 Томилолт, зочны зардал	23,000	21,530
61	3.1.01.2.1.1.7.02 Дотоод албан томилолт	23,000	21,530
62	3.1.01.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,562,000	1,538,920.11
63	3.1.01.2.1.1.8.01 Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,549,500	1,531,083.3
64	3.1.01.2.1.1.8.03 Даатгалын үйлчилгээ	3,638	3,198.91
65	3.1.01.2.1.1.8.04 Тээврийн хэрэгслийн татвар	140	138.95
66	3.1.01.2.1.1.8.05 Тээврийн хэрэгслийн оношлогоо	522	157.48
67	3.1.01.2.1.1.8.06 Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,800	1,005
68	3.1.01.2.1.1.8.07 Газрын төлбөр	6,400	3,336.47
69	3.1.01.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал	245,241	195,613.34
70	3.1.01.2.1.1.9.01 Бараа үйлчилгээний бусад зардал	238,641	191,966.34
71	3.1.01.2.1.1.9.02 Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,600	3,647
72	3.1.01.2.1.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,066,190.26	7,421,468.64
73	3.1.01.2.1.4.1 Засгийн газрын урсгал шилжүүлэг	8,041,190.26	7,406,630.34
74	3.1.01.2.1.4.1.01 Засгийн газрын дотоод шилжүүлэг	8,041,190.26	7,406,630.34
75	3.1.01.2.1.4.1.03 Төсвийн санхүүжилт	0	0
76	3.1.01.2.1.4.2 Бусад урсгал шилжүүлэг	25,000	14,838.3
77	3.1.01.2.1.4.2.07 Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	9,000	9,000
78	3.1.01.2.1.4.2.08 Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	16,000	5,838.3
79	3.1.01.2.2 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,710,515.8	2,135,291.19
80	3.1.01.2.2.4 Бусад хөрөнгө	2,710,515.8	2,135,291.19

81	3.1.01.2.3 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	600,000	1,290
82	3.1.01.2.3.1 Эргэж төлөгдөх зээл	600,000	1,290
83	3.1.01 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-2,851,462.86	-1,139,264.26
84	3.1 АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-2,861,462.86	1,139,264.26
85	3 Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-2,861,462.86	1,139,264.26
86	4 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	2,851,462.86
87	5 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	1,712,198.6
88	6 ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	86	80
89	6.1 БАЙГУУЛЛАГЫН ТОО	2	2
90	6.1.01 Төсвийн байгууллага	2	2
91	6.2 АЖИЛЛАГСАДЫН ТОО	43	40
92	6.2.01 Удирдах ажилтан	11	11
93	6.2.02 Гүйцэтгэх ажилтан	22	19
94	6.2.03 Үйлчлэх ажилтан	6	6
95	6.2.04 Гэрээт ажилтан	4	4
96	6.5 ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	43	40
97	6.5.01 Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	17	14
98	6.5.09 Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	13	13
99	6.5.10 Гэрээт ажилтан	4	4
100	6.5.11 Улс төрийн албан хаагч (УТ)	9	9

## **2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

**/мянган төгрөгөөр/**

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
1	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,015.0</b>
2	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,015.0</b>
3	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,015.0</b>
4	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	<b>1,015.0</b>
5	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,015.0</b>
6	Нэмэлт санхүүжилтийн орлого	<b>1,015.0</b>

## Гурав. Аудитын илрүүлэлт:

### **Завсрын аудитаар:**

“Сүмбэр сумын Засаг дарга”-ын 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн нэгтгэсэн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар залруулга хийгдээгүй байна.

Аудитаар нийт 1,448.0 сая төгрөгийн 4 зөрчил<sup>1</sup> илэрснээс, 4.0 сая төгрөгийн 1 төлбөрийн акт, 1,050.5 сая төгрөгийн 2 албан шаардлага, 393.4 сая төгрөгийн 1 зөвлөмж хүргүүлсэн байна.

### **Харьяа байгууллагууд**

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 2 тусгай сангийн, 1 “Энхтусдэм” ӨЭМТ, нийт 5 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 1 байгууллагад “Өөрчлөлтгүй” дүгнэлт гаргаж, 3 байгууллага түүвэрт хамрагдаж, “Энхтусдэм” ӨЭМТ аудитад хуулийн хугацаанд хамрагдаагүй, аудитад шаардлагатай баримт материал ирүүлээгүй тул татгалзсан дүгнэлт өгсөн байна.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 270.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 0.9 сая төгрөгийн 2 алдааг аудитын явцад залруулж, 2.1 сая төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 11.3 сая төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага, нийцлийн аудитаар 256.3 сая төгрөгийн 5 албан шаардлагыг хүргүүлсэн байна. /Хавсралт 1-ээс үзнэ үү/

Өмнөх онтой харьцуулахад харьяа байгууллагуудын нийт зөрчлийн дүн 33% буюу 135.6 сая төгрөгөөр буурсан байна. Төлбөрийн акт 2.0 сая төгрөгөөр нэмэгдсэн, албан шаардлага 75%-аар буюу 3 албан шаардлага нэмэгдсэн, зөвлөмж 100% буурсан байна.

Залруулагдаагүй нийт зөрчлийн 1,461.4 сая төгрөг нь бидний тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс их тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

### **5.1 Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага**

#### **5.1.1 Төлбөрийн акт**

- ОНХС-гийн барьцаа дансанд барьцаа хөрөнгийн хугацаа дууссан, он удаан жил болсон, ажил дутуу хийгдсэний улмаас чөлөөлөх боломжгүй 1 ажлын үлдэгдэл 4.0 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэж эргэлтэд оруулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2-т “жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх;”, 15 дугаар зүйлийн 15.4-т “Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:”, 15.4.1-т “төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8–д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх;”, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-т “Аймаг, сум, нийслэл, дүүргийн төсвийн орлогын нэр төрөл, зарлагын ангилал, санхүүжилтийн зориулалт болон төсөв зохиох, батлах, гүйцэтгэлийг зохион байгуулах, тайлагнах, хяналт тавих үйл ажиллагааг энэ хуульд заасан зарчимд нийцүүлэн Төсвийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна.”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.4-т “нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах;” заалтуудыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: Орон нутгийн орлогод төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв.

### **5.1.2 Албан шаардлага**

- ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийгдээгүй тайланг нэгтгэсэн, өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй /"Энхтусдэм" өрхийн эрүүл мэндийн төв нь 2025 оны санхүүгийн тайландаа аудит хийлгээгүй/

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн дутхай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.4-т “нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах” гэсэн заалтуудыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх оны зөвлөмжийг биелүүлээгүй тул албан шаардлага хүргүүлэв.

- Өмнөх онд үүссэн "Энхтусдэм" ӨЭМТ-д орон нутгийн төсвөөс илүү олгосон санхүүжилтийн 4.2 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй, 2 жил дараалан он дамжсан, холбогдох арга хэмжээ авч ажиллаагүй, бүртгэлээр тавих хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 15 дугаар зүйлийн 15.4-т “Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:”, 15.4.1-т “төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8–д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-т “нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах” гэсэн заалтуудыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Авлагыг барагдуулах албан шаардлага хүргүүлэв.

### **5.2 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Нэгтгэсэн тайлантай холбоотой асуудал**

1.1. Илрүүлэлт: Татварын орлогын төлөвлөгөө 393.4 сая төгрөгөөр тасарсан, хуулиар тогтоосон орлогын биелэлтэд хяналт тавьж ажиллаагүй

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2-т “жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх”, 42 дугаар зүйлийн 41.2-д “Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ”, 41.2.1 “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх”

гэсэн заалтуудыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хуулиар тогтоосон татварын орлого, төлөвлөгөөг бүрэн биелүүлж ажиллах

Дээрх төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилтийг тогтоосон хугацаанд, зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн дотор, Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь заалтын дагуу шийдвэрийн хэрэгжилтийн төлөвлөгөөг хуулийн хугацаанд тус тус Төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:  
Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/ сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Сүмбэр сумын ИТХ	1	0.1			1	0.1	1	0.1				
Сүмбэр сумын ЗДТГ	1	0.8			1	0.8	1	0.8				
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>0.9</b>			<b>2</b>	<b>0.9</b>	<b>2</b>	<b>0.9</b>				

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Сүмбэр сумын Засаг дарга	4	1,448.0	1	4.0	2	1,050.6	1	393.2				
Сүмбэр сумын ИТХ	4	3.9	1	0.5	1	3.4			2	0		
Сүмбэр сумын ЗДТГ	2	2.7	1	1.6	1	1.1						
Сүмбэр сумын ОНХС	2	6.7			2	6.7						
Энхтүсдэм ӨЭМТ												
<b>Нийт</b>	<b>11</b>	<b>1,461.3</b>	<b>3</b>	<b>6.1</b>	<b>6</b>	<b>1,061.8</b>	<b>1</b>	<b>393.2</b>	<b>2</b>	<b>0</b>		

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/сая төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Сүмбэр сумын ЗДТГ	1	11.9			1	11.9		-
Сүмбэр сумын ОНХС	1	36.9			1	36.9		
Сүмбэр сумын ХХС	1	207.5			1	207.5		
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>256.3</b>			<b>3</b>	<b>256.3</b>		
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>256.3</b>			<b>3</b>	<b>256.3</b>		<b>-</b>

**Тав.Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ								
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ	1	1			1			
5	ТЕЗ								
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>			<b>1</b>			